

# БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл
Өлгий хот	Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com
2026 он	Аудитын менежер: Х.Женисбек
	Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
	Ужиг Алтай Аудит ХХК-ны Захирал: Г.Ганболд
	Утас: 99117121 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫ ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Б.ЖАНСЕРИК ТАНАА

2026.02.16 № 80  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Алтай сумын ерөнхий боловсролын сургууль нь төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс 2025 оны жилийн эцэст ажиллагсадтай холбоотой 104.4 сая төгрөгийн, халаалтын 88.0 сая төгрөгийн өглөгтэй гарч оны эхнээс 105.4 сая төгрөгөөр нэмэгдсэн, халаалтын зардал төлөх талбайн хэмжээ баталгаажуулалт хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дахь заалтуудыг зөрчсөн санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, толилулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Алтай сумын ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 4,480.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 4,415.3 сая төгрөг зарцуулж, 98.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

832605000347

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

**ХОЁР.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,643,212,000.00</b>	<b>4,415,390,796.16</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,643,212,000.00</b>	<b>4,415,390,796.16</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,517,231,900.00</b>	<b>4,302,515,215.16</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,351,313,300.00</b>	<b>3,339,903,297.00</b>
210101	Үндсэн цалин	2,059,953,200.00	1,964,493,825.46
210102	Нэмэгдэл	1,265,092,100.00	1,235,585,751.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт		61,881,717.00
210104	Урамшуулал	26,268,000.00	77,942,003.45
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>418,914,300.00</b>	<b>418,328,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	284,861,700.00	284,463,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	33,513,200.00	33,466,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,756,600.00	16,733,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	16,756,600.00	16,733,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	67,026,200.00	66,932,700.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>372,076,000.00</b>	<b>283,362,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,338,000.00	10,338,000.00
210302	Түлш, халаалт	361,738,000.00	273,024,300.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>188,954,500.00</b>	<b>128,849,420.00</b>
210502	Хоол, хүнс	188,954,500.00	128,849,420.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>1,340,000.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,340,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>46,515,100.00</b>	<b>33,798,005.16</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		5,763,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	46,515,100.00	28,034,805.16
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>137,958,700.00</b>	<b>96,933,493.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	123,198,500.00	82,992,693.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,760,200.00	13,940,800.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>125,980,100.00</b>	<b>112,875,581.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>125,980,100.00</b>	<b>112,875,581.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	125,980,100.00	112,875,581.00
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,643,212,000.00</b>	<b>4,282,161,500.00</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>4,133,830,000.00</b>	<b>3,990,481,100.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,133,830,000.00	3,990,481,100.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>373,576,000.00</b>	<b>284,702,300.00</b>

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Орон нутгийн төсвөөс	373,576,000.00	284,702,300.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>135,806,000.00</b>	<b>6,978,100.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,938,200.00	6,978,100.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	128,867,800.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>205,378,701.04</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>72,149,404.88</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	124.00	124.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	68.00	68.00
620003	Үйлчлэх ажилтан	55.00	55.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	817.00	817.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	817.00	817.00
630001	Төрийн өмчит ЕБС	817.00	817.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>124.0</b>	<b>124.0</b>

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 449.6 сая төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан болно.  
Залруулсан алдаа:

- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 368.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу тайлагнасан.
- Мөнгөн гүйлгээний тайланд түлш, халаалтын зардлыг 44.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 30.1 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвийн санхүүжилтийг 7.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан.

Дээрх зөрчил нь төсвийн гүйцэтгэлийг бодитой бус харагдуулах, орлого, зардлын тэнцвэрт байдалд нөлөөлөх эрсдэл үүсгэж байсан тул холбогдох орлого, зардлын ангилалд бүрэн тусган тайлангийн мэдээллийг үнэн зөв болгох залруулгыг аудитын явцад хийлгэсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар 104.4 сая төгрөгийг 3 зөвлөмж өгөв. Үүнд:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Ажиллагсадтай холбоотой үүссэн өглөгтэй холбоотой асуудал**

1. Тус сургууль нь төсвийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснээс 2025 оны жилийн эцэст цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 88.0 сая төгрөгийн, нийгмийн даатгалын шимтгэлийн 16.3 сая төгрөгийн нийтдээ 104.4 сая төгрөгийн өглөгтэй гарч ажиллагсадтай холбоотой өр төлбөр оны эхнээс 25.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд төсөвт тусгагдаагүй хоолны хөнгөлөлтөд 62.9 сая төгрөг олгосон нь тодорхой хэмжээнд нөлөөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой бхй батламж мэдэглийг хангахгүй байна.

#### 1.2 Өгсөн зөвлөмж:

Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж өр төлбөр үүсгэхгүй байх, өр төлбөрийг барагдуулах арга хэмжээ авах, төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах;

### **2. Түлш халаалтын зардлын гэрээ, тооцоотой холбоотой асуудал**

#### 2.1 Илрүүлэлт:

Сургуулийн захирал 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр “Нур-Төре” ХХК-тай дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулахдаа Эрчим хүчний зохицуулах хорооны хүчингүй болсон 2014 оны 189 дүгээр тогтоолыг үндэслэл болгосон, гэрээнд халаалт авах нийт талбайн хэмжээ, төлбөрийн дүнг тодорхой тусгаагүй байна.

Мөн сургуулийн хуучин, шинэ хичээлийн байр, дотуур байр, спорт заалны халаалтын нийт талбайг мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэж баталгаажуулаагүй, батлагдсан үнэ тарифын дагуу гэрээ байгуулаагүй байна. Сургуулийн халаалтын нийт талбайд үндэслэн батлагдсан төсвөөр 361.7 сая төгрөгийн халаалтын зардал төлөхөөр тооцоолсон байна. Тайлант онд халаалт нийлүүлэгч компанид 273.0 сая төгрөгийг төлж, 88.7 сая төгрөгийн өглөг үүсгэн санхүүгийн тайланд тусгасан байна.

Халаалтын үйлчилгээний гэрээг Эрчим хүчний зохицуулах хорооны 2014 оны 189 дүгээр тогтоолд үндэслэн байгуулсан боловч уг тогтоол нь хүчингүй болсон байна. Мөн барилга, байгууламжийн халаалтын талбайн хэмжээг (м<sup>2</sup>) нарийвчлан тогтоогоогүй, Баян-Өлгий аймгийн Зохицуулах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Тариф батлах тухай” тогтоолыг мөрдөөгүй зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 зүйлийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

## 2.2 Өгсөн зөвлөмж:

Дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг Эрчим хүчний тухай хууль болон Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 164 дүгээр тогтоолоор баталсан “Дүрэм шинэчлэн батлах тухай” дүрэмд нийцүүлэн шинэчлэн байгуулах, гэрээнд халаалт авах талбайн хэмжээ, төлбөрийн мөнгөн дүнг тодорхой тусгаж, халаалтын зардлын төсвийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сайжруулах,

## **3. Бараа материал худалдан авах ажилгаатай холбоотой асуудал**

### 3.1 Илрүүлэлт:

Сургууль нь аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан хүнс, бараа материал худалдан авах гэрээнд гэрээний үнэ, нийлүүлэх хүнс, бараа материалын тоо хэмжээ, үнийн дүнг тодорхой тусгаагүй байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих боломжгүй болох эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-т “Захиалагч шалгарсан оролцогчийн хооронд байгуулах бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээ /цаашид “худалдан авах гэрээ” гэх/-ний гол нөхцөл нь тендер шалгаруулалтын баримт бичиг болон шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендер байна” 39.2-т “Худалдан авах гэрээний үнийг гэрээ байгуулах эрх олгосон тухай шийдвэрт заасан үнээр тогтооно”, 39.3-т “Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана” батламж мэдэгдлийг хангахгүй байна, 39.3.1-т “гэрээний үнэ”, 39.3.2-т “гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл” заалтуудтай нийцэхгүй байна

### 3.2 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу худалдан авах гэрээг байгуулж, гэрээний хэрэгжилтэд тавьж ажиллхыг зөвлөмж болгов.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТГТайлан зөрүүтэй тайлагнасан	1	368,028.6	1	368,028.6			1	368,028.6				
үр дүнд мөнгөн гүйлгээний тайланд түлш, халаалтын зардлыг 44.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан, үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг 30.1 сая төгрөгөөр дутуу тооцсон, санхүүгийн үр дүнгийн тайланд улсын төсвийн санхүүжилтийг 7.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан зөрчил тус тус илэрсэн.	1	81,700.2	1	81,700.2			1	81,700.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>449,728.8</b>	<b>2</b>	<b>449,728.8</b>			<b>2</b>	<b>449,728.8</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал	3	104,391.9					3	104,391.9				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>104,391.9</b>					<b>3</b>	<b>104,391.9</b>				

Алтай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээллийг дутуу байршуулсан	1	95,511.3					1	95,511.3
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>95,511.3</b>					<b>1</b>	<b>95,511.3</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>95,511.3</b>					<b>1</b>	<b>95,511.3</b>